



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 5 сарын 25 өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

Нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4 дэх заалт, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 18 дугаар тойрогт “Сахигтун! Үндсэн хуулийн 19” эвслээс нэр дэвшүүлсэн Бямбажавын Уранцэцэг нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2, 32.2.3, 32.2.4, 32.2.5, 32.2.6, 32.2.7, 32.2.8, 32.2.9-д заасан баримт бичгийг дутуу ирүүлсэн тул нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсугай.

ДАРГА *Ч. Содном* Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Ц. Болдсайхан* Ц.БОЛДСАЙХАН